

1362 ОНЫ ИНДУ ВАНГИЙН ХӨШӨӨНИЙ БИЧЭЭС ХИЙГЭЭД  
Ф. В. КЛИВИЗИЙН СУДАЛГАА

Ш. Чоймаа\*  
М. Баярсайхан\*

Бидний үед уламжлан ирсэн монгол хэлээр, уйгуржин үсгээр бичсэн хөшөөний бичээснээс хэмжээний хувьд том дурсгалын нэг нь 1362 онд босгосон Инду вангийн гэрэлт хөшөөний бичээс юм. Гэрэлт хөшөө чулууны магнайн бичээс дэх “Их Монгол улсад зарлигаар Си нин он Инду-д байгуулдсан бэй таш” хэмээх нь хөшөөний бүтэн нэр болно<sup>1</sup>. Тус хөшөө БНХАУ-ын Ганьсу мужийн У-Вэй хотоос хойш гучин газар орчим зайтай Шибэйкоу гэдэг газарт буй хэмээдэг<sup>2</sup>. Монгол бичээс нь нийт 54 мөр, 1500 орчим үгтэй.

Тус хөшөөний уйгуржин монгол бичгийн тухай анх мэдээлсэн хүн бол П.Пельо юм. П.Пельо 1908 онд тус хөшөөний монгол бичгийн хуулбар дардсыг олсны дараа зохиол бүтээлдээ хэдэнтээ дурдаж, эш татаж байсан боловч, хөшөөний бичээсийг тусгайлан судалж, нийтлүүлсэн зүйлгүй ажээ. Тус хөшөөний бичээсийг анх нарийн нягт, бүрэн судалсан эрдэмтэн бол Ф.В.Кливиц юм. Түүнийг 1941 онд Бэйпин (одоогийн Бээжин)-д байх үед Ж. С. Фергюсон хэмээх хүн хөшөөний монгол бичгийн дардсыг хүргэж, англиар орчуулан хэвлүүлэхийг дургасан гэдэг. Ф.В.Кливиц 1942 онд “1362 оны Инду вангийн хөшөөний нангиад монгол бичээсийн судлал” (The Sino-Mongolian Inscription of 1362 in Memory of prince Hindu) сэдвээр Харвардын Их сургуульд гүн ухааны докторын зэрэг хамгаалжээ. Хожим өмнө бичсэн өгүүлэлдээ засвар оруулан Харвардын Их сургуулийн Азийн судлалын сэтгүүлийн 1949 оны 12 дугаарт нийтлүүлсэн бөгөөд бас тусгай дэвтэр болгон хэвлүүлсэн байна. Үүндээ, хятад ба монгол бичээс тус бүрийг англиар орчуулан агуулга, нэр томъёо, үг хэллэгийг түүх, түүхэн хэлзүйн үүднээс шинжилсэн дэлгэрэнгүй тайлбар хийж, монгол бичээсийн эрдэм шинжилгээний галиг, үгийн хэлхээ бүхий эх бичгийн бүрэн судалгаа хийснээс гадна, Тогоонтөмөр хааны үеийн нангиад монгол бичээс бүхий нийт зургаан хөшөө чулууны талаарх танилцуулга бүхий удиртгал бичиж, тус хөшөөний бичээсийн гэрэл зургийг анх удаа нийтэлжээ. Энэ зохиол нь түүний сурвалж судлалын ажилд ханцуй шамлан орсон анхны туршлага гэхэд нэлээд нямбай бүтээл болж чаджээ. Ер нь Ф.В.Кливиц гуай хэл бичгийн дурсгалыг судлахдаа, бүхэлд нь тун нягт гярхай анхааран үзэж, боломжит бүх талаас нь төгс нарийвчлан шинжилсэн байдаг. Түүний бичсэн монгол хэл ба бичгийн дурсгалын

\* Монгол Улсын Их Сургууль, Монгол Хэл Соёлын Сургууль

<sup>1</sup> Мөн бичээсийг “Си нин ван Инду-д босгосон хөшөөний бичиг”, “1362 оны хятад монгол хөшөөний бичиг”, “Инду вангийн хөшөөний бичээс” гэх зэргээр нэрлэдэг.

<sup>2</sup> Tufayurigi, «Indu ong-un kösiy-e»-yin mongyol biçig-ün sudulul. ÖMSKQ, 1990, 1дүгээр талд.

### Ш. Чоймаа, М. Баярсайхан

олонх судалгаа нь тухайн сэдвийг бараглаж, эцэст нь хүргэсэн байдаг гэж болно. Сурвалж судлалын бүтээлүүдэд судлаачид аль нэгэн бэрх ярвигтай зүйлийн талаар дурдалгүй орхисон байх нь цөөнгүй байдаг бол Ф.В.Кливиз гуайн судалгаанд тийм зүйл огт байдаггүй. Тэр бээр судалгааны ажилд шударга, элэгтэй ханддаг байсан тул, учир нь үл олдох бэрх үг, бичлэгийн талаар заавал дурдаж, ямар нэг санал хэлдэг бөгөөд үнэмшил багатай санагдсан зүйлээ ийм байж болох юм, гэхдээ үүний учрыг би тодруулж чадсангүй хэмээн тэмдэглэсэн байдаг.

Тус хөшөөний монгол бичээсийн талаар Ф.В.Кливизийн судалгаанаас гадна, Л.Лигети, Д.Төмөртоогоо нарын латин галиг, Тулгуурын «Индү вангийн хөшөө»-ний монгол бичгийн судлал хэмээх ганц сэдэвт зохиол, Тулгуур, Сод нарын “Индү вангийн хөшөөний бичиг дэх тийн ялгалын дагавар -i, -yi-гээс сэдэвлэх нь” өгүүлэл, Тулгуурын “Индү вангийн хөшөөний бичгийн тухай” өгүүлэл тус тус гарснаас гадна, Дов “Уйгуржин монгол үсгийн дурсгалт бичгүүд” эмхтгэлдээ сийрүүлэг, гэрэл зургийг нь нийтэлжээ. Мөн Өвөр Монголын эрдэмтэн Иринчин 1983 онд тус хөшөөний латин галигийг үйлдэж, хятад үсгийн орчуулга хадан цөөн үгсийг тайлбарласан<sup>3</sup> байна.

Судлаач Тулгуур 1990 онд хэвлүүлсэн “«Indu ong-un kösiy-e»-yin mongyol bičig-ün sudulul” хэмээх бүтээлдээ хөшөөний уйгуржин бичгийн дуудлагын болон бичгийн галиг, хөшөөний бичгийн авиазүй, үсэгзүй, бичлэгийн дүрэм, үгсийн бүрэлдэхүүн, хөшөөний бичиг дэх үгзүйн үзэгдэл, үгсийн аймгийн зарим асуудал, өгүүлбэрзүйн зарим асуудлыг тус тус бүлэг болгон оруулсан байна. Түүндээ уг бичээсэнд гарч буй түүхэн хүмүүс, газар орон, албан байгууллага, цол тушаал, он жилийн нэр, түүхэн хэрэг явдлыг “Юань ши”, “Мин ши” болон бусад хятад сурвалжаас магадлан тодруулсан нь чухал судалгаа болжээ. Тэр бээр Ф.В.Кливизийн зохиолыг үзэж ашиглахдаа үгийг унших, утгыг тайлах тухайд санал нэгдсэн ба санал зөрсөн зүйл цөөнгүй дурдсан байдаг. Гэвч, зарим газар Ф.В.Кливизийн бичсэнийг үндэсгүй шүүмжлэн, судалгааны ажилд үл нийцэх хандлага гаргажээ.

Энэ дурсгалыг төрд хүчээ өгсөн гавьяатан сайд Орон, түүний урьдас дээдэс нийт таван үеийнх нь гавьяа зүтгэлийг алдаршуулахын учир босгожээ. 1362 онд Орон амьд сэрүүн байсан тул, хөшөөг хэнд зориулсныг бичихдээ эцэг нь Индү ванд байгуулснаар тавьжээ. Элэнц өвөг нь даруй “Монголын нууц товчоон” (МНТ), Юань улсын судар, Рашид ад-диний Судрын чуулган зэрэгт гардаг Чингис хаанд хүчээ өгсөн “Уйгудын хан Барчуг Ард Идуг куд” хэмээх бүлгээ. Эрдэмтэн Сайшаал “Чингис хааны товчоон” хэмээх зохиолдоо тодолсныг хураангуйлбал, “Итүгүд” хэмээх бол хүний нэр биш, уйгур үндэстний хан цол агаад чухам нэр нь Баржуг Арт тигин болно. Тэр 1208 онд Мэргидээс дутаасан Худу лугаа байлдан дийлсэн, дараа хавар нь Уйгурыг захирч байсан Хар хятаны сүүлчийн захирагч Шаокэм-ийг алж, Чингис хаанд элч илгээн хүчээ өгсү хэмээн хэлүүлжээ. 1211 онд их хаанд бараалхсанд, Чингис хаан Ал Алтун бэхи охиноо өгсөн ба Чингис хаанаас хойш түүний үр хойч нь ургийн ургаараа Монголын төрд үйлчилж, төрийн хүргэн болж байв гэжээ<sup>4</sup>. “Индү вангийн хөшөөний монгол бичээс” бол дундад үеийн монгол хэлний онцлогийг тусгасан, яруу сайхан найруулга бүхий хэл, түүхийн дурсгал төдийгүй, 30 мөр төгсгөлийн шүлэг нь уран зохиолын нэгэн дурсгал билээ.

Тус хөшөөний бичээсийн зарим анхаарал татсан баримт, үг хэллэгийн талаар цөөн жишээ дурдая.

<sup>3</sup> Y.Irinčin-ü mongyol sudulul-un büttügel-ün čiyulyan, ОМАКQ, 2001, 627-693 дүгээр талд.

<sup>4</sup> Сайшаал, Чингис хааны товчоон. Уб. 2010. I боть. 513-516 т.

### Ш. Чоймаа, М. Баярсайхан

**tobčiyān.** Бичээсийн 46-47 дугаар мөрт: “Bi öčügüken boyol tüsimel Ui suu ülü čidaqu budayu oyitu kümün bögetele urida tobčiyān j-a qadayałaysan-ača šiltayalan yadaju ayuyad emiged bii tas-un ayalyus-i šilüg selte joqiyaju nögčigsen uridus-un anu ner-e-yi iren odun yabuqu mör deger-e bayiyulqu šiltayan kemebesü” гэж бичжээ. Энд “товчоон” хэмээх үг гарч буй нь уйгуржин үсгээрх монгол хэлний дурсгалууд дахь хамгийн анхны тохиолдол бөгөөд “Монголын Нууц Товчоон”-ыг заасан үг болохыг Ф.В.Кливиз онцлон тэмдэглэжээ. Үнэхээр эрдэмтний энэ санал ор үндэстэй юм. “...урьд товчоон за хадгалснаас шалтгаалан ядаж айгаад эмээгээд...” гэсэн орчмынх нь үгээс үзэхэд тэрхүү “товчоон” бол ерийн нэгэн зохиол бус, тусгайлан хадгалдаг, эрх дархгүй хэн хүн зоригоор үзэж болдоггүй онцгой зохиол болох нь тодорхой байна. Тус хөшөөний бичгийг зохиосон Уй суу түшмэл, монголчлон орчуулсан Эсэнбуха нар аль аль нь МНТ-г сайн мэддэг бичгийн сайд байсан биз ээ. Бичээсийн үг найруулгад МНТ-ны үг хэллэгтэй ойролцоо зүйл ч олон тохиолдож байна.

**keriske.** Бичээсийн 11 дүгээр мөрт “Qalqan kemebesü keriske metü yaјiyu dayisun-i qalqalaju qariyulqu-yi kemeуü.” гэсэн өгүүлбэр тохиолдож байна. МНТ-ны §124-д “gerisge isgei bolju ger jük gerisgeleldün qorisu ke’eba” гэж гардаг. Халх хэмээх үгийг хэрсэг хэмээн тайлбарласан нь тэрхүү үгийн утгыг улам тодорхой болгож байна.

**altan bey-e.** Инд. 4. “Činggis qayan tngri-yin joriy-i dayan ümedü yajar-ača yeke üile-yi büttügen altan beyeber ulus qamun ayalan yabuysan dötüger on-dur Uiyudun qan inu Barčuy Ard Iduy-quд medelün irgen-iyen abuyad oroju” гэжээ. Монголын түүхэн сурвалж бичгүүдээс Лувсанданзаны “Алтан товч”-д: “ejen-iyen altan beyen-dü sumun büü kürgesü gebe”(46a);

“altan bey-e-ben amusu kemebesü : aqu törü minu aldaruyjai:

bütün bey-e-ben amusu kemebesü :

bürin ulus minu samdurayujai :

altan bey-e minu aljiyabasу aljiyatuyai :

aqu törü minu büü aldaratuyai :


bütün bey-e minu jobubasu [=jobabasу] jobatuyai

bürin ulus minu büü samduratuyai” (106a) хэмээн алтан бие хэмээх үг гурвантаа гардаг.

Тэмгэгү-гийн 1925 онд хэвлүүлсэн “Чингис хааны цадиг”-г уламжилсан Чингис хааны билиг сургаалын дотор мөн энэ үг “Алтан биеэ амусу хэмээвээс, аху төр минь алдруузай” хэмээн гардаг. Чингис хааны зарлиг болсон энэхүү үгийг судлаачид “алд бие”, “алтан бие”-ийн алинаар унших тухайд санал зөрөлдөж иржээ. Үүнээс нэлээд нь “алд бие” гэж ойлгон, монгол хүн хэлж бичихдээ өөрийн биеэ доор болгож “өчүүхэн, мөхөс, болхи” гэхчилэн даруулгатай ханддаг, “алд бие” ч бас тийм үг юм хэмээн хэт эдүгээчилсэн тайлбар өгч иржээ. Чухамдаа, хаан хүн өөрийн биеийг “мөхөс хүн”, “доорд хүн” гэх зэргээр дарж хэлдэг нь эртнээс түгээмэл хятад заншил бөгөөд нүүдэлчин монголчуудын хувьд угаас тийм заншил байсан гэхэд тун эргэлзээтэй юм. Тэгвэл хааны биеийг “алтан бие” хэмээх нь тогтсон үг байсныг тус бичээсийн үг нотолж байна. Түүнчлэн эл бичээсэнд altan гэдэг үг “altan büs-e”, “altan čirai” хэмээн нийт гурван удаа гарч буй нь цөм Чингис хаанд хамаатуулж хэлжээ. Алтан бие, алтан царай, алтан ураг гэх мэт хэллэг нь хамгийн эрхэм дээд гэсэн утга илтгэж, тэр цагт зөвхөн Чингис хаанд холбогдуулан хэлж байсан заншил болох нь илэрхий. Өнгө чанар нь үл хувирах алтаар аливаа эрхэм дээд зүйлээ адилтган нэрлэх ёс бол монголчуудын хэл сэтгэлгээний эртний онцлог юм. “Монголын Нууц Товчоон”-д “алт (alta-altan)” хэмээх үг хүний нэр цолын бүрэлдэхүүн болж орсноос гадна, 33 удаа тохиолдоно. Үүнд, эдлэл хэрэгслийн нэрээр 11 удаа, өргөл бэлэг, олз татварын зүйлээр 14 удаа гарахаас гадна, алтаар зүйрлэж өгүүлсэн нь 8 удаа тэмдэглэгджээ. Бидний сонирхож байгаа нь алтаар зүйрлэсэн жишээ баримт бөгөөд “алтан амь”, “алтан босго”, “алтан аргамж”,

### Ш. Чоймаа, М. Баярсайхан

“алтан жолоо”, “алтан бие” гэх мэт буй. “Алтан биес”-ийн “алтан аргамж” болсон уг удмын хэлхээ холбоог мөн л “алтан ураг” хэмээнэ.

**bayiuldaysan.** мо.б.  bayiuldaysan. Монгол хэлний үйл үгийн үйлдэгдэх хэвийн нөхцөл нь -ta,-te; -da,-de; -yda,-gde хувилбартай. Үүнээс зөөлөн дэвсгэр гийгүүлэгчээр төгссөн үндсийн хойно угтаа гийгүүлэгчийн чанга сулын зохицол дагуу -da, -de хувилбарыг дагуулж байв. Эдүгээгийн -гд /-yda/ хувилбар бүхий “байгуулагд-” хэмээх хэлбэр багцаалбал, XVI зууны үеэс аажмаар хэвшсэн бололтой юм. Үүнчлэн oralayuldabasu, aldarsiuldamui зэрэг үйлдүүлэх хэвийн -da/-de нөхцөлтэй үгс тохиолдож байна. Дашрамд өгүүлэхэд, монгол хэлний зүйн судалгааны бүтээлүүдэд эдүгээг хүртэл үйлдэгдэх хэвийн нөхцөлийн -da/-de хувилбарын тухай төдийлэн дурдалгүй явж иржээ. Монгол хэлний olda- (олдох), bolda- (болдох), duulda-(дуулдах), tasulda-(тасалдах) зэрэг үгийн хэвийн нөхцөлийг үт бүтээх дагавар гэж үзсээр ирсэн байна.

**tür-ün.** Инд.14. “Činggis qayan tür-ün ulus qamun yabuqui-dur mön qalqanliq Qar-a totoγ Iduy-qud-tur südkün duradqaju”. Энэ үгийг түрүүн, тэргүүн хэмээх үгийн бичлэг гэж үзэв. “Хуа-и и-юй”-гийн доод дэвтэрт буй “Зарлигаар төрийн журганаас Йин Чан-Вэй-д өгсөн бичиг”-ийн 17v4-д “Törün Tcheu-tcheng harban nikentü'er hon-nača. ulus irgen jасау-ача inu ülü ayun” хэмээн бичжээ. Үүний эхний үгийг “түрүүн” хэмээх үгээр орчуулсан байдаг. “Хуа-и и-юй” бичиг дэх албан баримтуудын галигт ügü'ülgü (үхүүлэх), gü'ün (хүн), yabu'ulun (явуулан) гэх мэтээр үүсмэл урт эгшигтэй үгийн эгшгийн хоорондох амьсгалын түрэлтийг ямагт тэмдэглэсэн байх атал, түрүүн хэмээх үгийг türün-törün гэж галигласан байна. Энэ нь тухайн үгийг монгол бичгээр уртатгалтай, уртатгалгүй хоёр янзаар бичдэг байсныг харуулж байна.

**eten.** Инд.16. “kücü ögkü-yi erkilen ulus-a qour-tu üiles-i eten tus-a-tu-yi yabuyuluysabar olan-a maši sayišiyaydaysan ajuγu”. Үүнийг хамах гэсэн утгат этэх гэсэн үг гэж үзэв. МНТ-д itejü гэсэн хэлбэрээр гардаг. МНТ 234§-д “Dödei cerbi darun aju ordo-yin qoyinaca qoq itejü qoma'ul tülejü yabutuqai” гэсэн өгүүлбэр бий. МНТ-ны хажуугийн хятад орчуулгад “хог идэх” гэж орчуулсан нь илэрхий ташаарал болох нь, өгүүлэмжийн утга авцалдахгүй байгаа, бусад сурвалж дахь дүйх хэсэг зэргээс үзэхэд тодорхой болж байна. Энэ хэсгийг Лувсанданзаны Алтан товчид “dödei cerbi darun aju : ordu-yin qoyina-ača qoγ abču qomuγul tülejü yabutuγai”, Асрагч нэргийн түүхэнд “ger mal-un jüγil-i dödei cerbi medejü: yоγuqan-dur bayuju qoγ qamuju qomuγul tülejü yabutuγai” хэмээн тус тус утгыг нь тодорхой болгон ойролцоо үгээр нь солин найруулсан байдаг. Хуа и и-йү зэрэг дундад үеийн монгол хэлний бичгийн дурсгалаас үзэхэд, хамах гэдэг үгийг хамж цуглуулах, хамж арилгах гэсэн хоёр утгаар хэрэглэсэн тохиолдож байна. 17 дугаар зууны үеийн халх аялгуунд “ete-” гэдэг үгийн хэрэглээ хязгаарлагдмал, нийтэд ойлгомжгүй үг болчихсон байсан тул, тэр үеийн түүхчид олны мэдэх ойролцоо утгат үгээр сольсон биз ээ. “МНТ”-ны 234-р зүйлд гарах “itekü” хэмээх нь “этэж хамах” гэсэн утгатай болохыг түрэг хэлний баримт давхар нутлаж буй. Эртний түрэг хэлэнд “idi-” (собирать<sup>5</sup>) нь “цуглуулах, эмхлэн хураах” хэмээсэн утгатай ажээ.

**köbegün sibayun.** Инд. 29. “irgen-i öber-ün köbegün sibayun metü tayalaju yabubasu ta eregü qour-tur ülü oroγad”. Энэ хоршоо үг “Хуа-и и-юй” толь дахь Нэхэлэйн бичигт: “Ta ming qahan. tenggiri-yin jaya'an-bar. delegei-yin ulus-i. kö'ün šiba'un metü. alaқcin ügei. enerin qayiralaqu. a'ui delger joriq. бүkүй-yin tula.” /12v3-5/ хэмээн нэг удаа тохиолдож байна. Орчин цагийн монгол хэлний “хүүхэд шуухад” гэсэн хоршоо үг угтаа энэ үгээс хувирсан хэлбэр байж магадгүй. Бээжин барын Гэсэрийн туужид “keüked siyuqad” хэлбэрээр тохиолддог. Их мянгадай Иринчин 子弟

<sup>5</sup> “Древнетюркский словарь” Академия наук СССР, Институт языкознание., Ленинград., 1969, 203-р тал.

/zidi/ (үгчилбэл “хүүхэд дүү”) хэмээн орчуулсан нь хүүхдүүд гэсэн утга илтгэнэ. А.Мостаэрт “Ордос толь”-доо хүүхэд хэмээх толгой үгийн дотор “хүүхэд шуухад” гэдгийг ‘les enfants’ гэж орчуулаад, “Хуа и и юй” бичигт бас “kō’ün šiba’un” гэж гардгийг дурдсан байна<sup>6</sup>. Энэ хоршоо үгийн “šiba’un” гэдэг нь жигүүртнийг заасан үг мөн эсэх, мөн бол эдгээр үг яагаад хорших болов гэдэг асуудал гарч байна. Бидний бодлоор энэ хоршоо үгэн дэх “šiba’un” бол жигүүртнийг заасан үг биш. Монгол хэлнээ мал зал, гар мар, бага сага, хөрс мөрс, улаан мулаан гэх зэргээр давтан хоршдог онцлог үзэгдэл ёсоор эхний авиаг нь “ш”-ээр сэлгэж, чанга эгшгийг нь ондоошуулан хөндий эгшгээр дуудсан хэрэг юм. Иймээс köbegün šiba’un, keüküd siuqad гэхээс бус köbegün siuqad, keüküd šiba’un гэж хоршдоггүй байна.

**unurtabai.** Инд. 52. “surγaju ele öggügsen söyüger-i činü: söni ödür saqiju es-e umurtabai:” Энэ үгийг Ф.В.Кливиз гуай “onurdabai”, Л.Лигети, Д.Төмөртогоо академич нар “umurtabai”, Тулгуур, Иринчин нар “onordabai” хэмээн тус тус галиглаж, Ф.В.Кливиз “омтгойдох”, Тулгуур “умартах” гэдэг үгтэй тус тус холбон тайлбарлажээ. С.Маловын “Памятники древнетюркской письменности” (1951) номд тэмдэглэснээр эртний түрэг хэлэнд unyt-, киргиз хэлэнд unut- хэмээх үйл үг “мартах” гэсэн утгатай аж. Иймд, тус бичээс дэх “unurtabai” хэмээхийг Алтай хэлний нийтлэг үгийн нэлээд эртний хэлбэр бүхий бичлэг гэж үзэж болох юм. Энэ үг зарим түрэг хэлэнд дараалсан гийгүүлэгчийн өмнөх нь сугарч unut-/unyt- хэлбэртэй болсон бол, монгол хэлэнд unurta-~umurta-~umarta-~март- хэмээн хувьссан байна гэж үзэлтэй. С.А.Старостин нар “Алтай хэлний үгийн гарлын толь”-доо өвөг алтай хэлний мартах гэдэг үгийг \*umun(t)o; түнт. \*om᠓a-; монг. \*umarta-, түр. \*umni-t-(~m᠓-) хэмээн тус тус сэргээжээ<sup>7</sup>.

**oyin.** Инд. 41. “ayali inu jibqulang deger-e oyin inu gegegen ulus-un yeke üile-dur dadmayai бүкүйн siltayabar”. Оюун хэмээх үгийг ийнхүү тэмдэглэжээ. Эндээс бидэнд “оуун” гэдэг үгийн гарал тодорхой болж байна. Судлаачид “оуун” гэдэг үгийг билигүүн, номуун хэмээх үгийн адил ой /oyi/ гэдэг үгийн араас харьяалахын тийн ялгалын –un орж хамт бичигдэн хэвшсэнээс үүссэн байж магадгүй гэж тааварладаг. Тэгвэл, ой ухааны “ой”/oyi/, оюун /oyun/ хэмээх хоёр үг угтаа нэг үг байгаад хэлбэр салахын хамт утга салаалжээ гэж үзэх нь зүйтэй байна. Ой гэдэг үг \*hoyin > oyin > oyi > ой хэмээн хувьссан байна. Нөгөөтээгүүр дундад үеийн монгол хэлэнд нэн түгээмэл байсан i~u, i~ü эгшгийн сэлгэцээр “oyin~оуун” гэсэн хоёр хэлбэр бий болж, “оуун” хэлбэрийн арын тогтворгүй –n нь хэвээр хадгалагдаж үлдсэн бөгөөд утгын хувьд аажмаар ялгамжаа бий болжээ. Хэлний урдуурх эгшиг хийгээд уруулын уйтан эгшиг харилцан сэлгэх үзэгдэл тун түгээмэл байсныг гэрчлэх дундад үеийн монгол хэлний жишээг bidayu~budayu, birayun~burayun, büsirekü~bisirekü, müsiyekü~misiyekü, ilegü~ülegü гэх мэтээр олныг дурдаж болно.

**nimtu-** 51 дүгээр мөрт “cegejiben nimtu: γayca oron-u kücü öggügsen-iyer” гэж буй. Энэ үгийг Ф.В.Кливиз гуай ‘nimtu’, Тулгуур ‘imtu’ гэж тус тус галиглажээ. Профессор Иринчин ‘imtu’ гэж уншаад 破 [pò] буюу “хэмхэрсэн, эвдэрсэн” хэмээх ханзаар утгыг нь тайлсан байна. Тулгуур « Одоо манд бас материал бүрэн биш байдал доор баталгаатай тайлбар хийж тайлсангүй, зөвхөн өгүүлбэр дэх өмнө хойтох үгсийн холбооноос язгуур нь “им тамга”-ын “im”, “imtu” гэдэг нь “гүн гүнзгий суугдал” гэдэг утгатай болов уу» хэмээн таамаглажээ<sup>8</sup>. Бидний бодоход, Тулгуурын таамагласнаар “nimtu” нь нэр үг байж хэрхэвч таарахгүй, харин үйлийн болцыг

<sup>6</sup> MOSTAERT, Antoine. Dictionnaire ordos. (Monumenta Serica. Monograph 5.) 3 vols. XII, (2), 950, (2)pp. Folio. Peking (The Catholic University), 1941-1944. 433p.

<sup>7</sup> S.A.Starostin, A.V.Dybo, O.A.Mudrak. An Etymological Dictionary of Altaic Languages., 1499 p.

<sup>8</sup> Tulyayuri, «Indu ong-un kösiy-e»-yin mongyol bicig-ün sudulul, 1992, Öbör Mongyol-un Soyol-un Keblel-ün Qoriy-a., 167 дугаар талд.

тодотгосон дайвар үг байж болмоор санагдана. Бүтцийн хувьд *nim-* язгуур нь “нимгэн” хэмээх үгийн язгуур, “-tu” дагавар нь үлт (*ültü*), мөлт (*möltü*), мулт (*multu*), халти (*qaltu*), шувт (*sibtu*), тувт (*tubtu*) зэрэг үгэнд орсон дагавар байж болох юм. Түнгүсийн хэлнүүдэд нимгэн хэмээх үг эвенк. *nemkun*, ма.б. *nekeliyen*, орк. *nemduke*, орч. *nemi/nemne*, сол. *nemeku/nenneku*, нан. *nemi* гэдэг аж. Цаашилбал, манж хэлний “*nime-*” хэмээх үйл үг өвдөх, шимшрэх гэсэн утгатай бөгөөд угтаа дээрх *nim-* язгууртай гарал нэг бололтой. Манжаар *nimembi* “өвдмүй”, *nimesuke* “аймшигтай” хэмээх үг. Монголчуудын “өр нимгэн” гэж хэлдэг нь өвдөх-шимшрэх-эмтрэх-нимгэн зэрэг үг утгын хувьд холбоос бүхийг илтгэж байна.

**ötegen.** 50 дугаар мөрд “*ösküleng urtu modun urγubasu ele oi-dur: uγayur inu gün-e ündüsüleyü ötegen-ü küi-dür*” гэж буй. Тулгуур бээр Ф.В.Кливизийн саналыг дэмжин «Энэ үг бол орчин цагийн монгол хэлний “газар” гэсэнтэй адил утгатай юм. Нууц Товчоонд үүнийг “*etügen*” буюу “*ötögen*” гэж хоёр янзаар бичиж байх бөгөөд хажуугийн орчуулгад нь бүр 地 гэж орчуулжээ» гэсэн байна. Иринчин гуай 大地 脐 /*liang qi*/ буюу этүгэний хүй хэмээжээ.

**öbedegsi.** Тулгуур ‘*übetegsi*’ гэж галиглаад, “өвтэгш”, “аугаа их, өргөн далайцтай, сүр жавхлан” гэсэн утгатай гэж үзсэн байна. Олонхийн ойлгодог шиг энэ үг “өв-тэгш” гэсэн хоёр үгийн нийлэмж биш ээ. Энэ үгийг “*öbedegsi*” гэж галиглавал зохих бөгөөд “Монгол үгсийн язгуурын толь”-д *ögede* хэмээх үгийн авиа сэлгэсэн хувилбар *öbede* гэдэг үндсэнд -*gsi* хэмээх чиглэх утгат орон заасан үг бүтээх дагавар залгаж бүтсэн<sup>9</sup> гэж үзсэнийг зүйтэй гэж үзэв. *Öger-e ~öber-e, degel~debel, igegekü~ibegekü* гэх мэт *g~b* авиа сэлгэх үзэгдэл байдгийн нэг жишээ нь энэ үгийн үндсэнд тохиолдож байна.

**üjügülen.** “*γayča nigen ödür-ün kičigel qatayujil-iyar güičegsen busu egenegte uyidqari ügei üjügülen kücü öggügseber*” (45-р мөр) Тулгуур: “язгуур нь үзүүр хязгаар, үзүүр зах”-ын *üjügür*, “*üjügülen*” нь дагавар залгахад “г” гийгүүлэгч гээгдсэн бөгөөд “үзүүрт нь тулах” гэсэн утгатай хэмээн зөв тайлбарлажээ.

**nisan.** 41 дүгээр мөрт “*qas nisan ber subutu jisün altan büs-e soyurqaydabai*”. “Тамга” гэсэн утгатай перс хэлний үг. Энэ үг нэлээн эрт түрэг, монгол, манж жүрчин зэрэг хэлэнд орсон бололтой бөгөөд монгол хэлнээ 13-14 дүгээр зууны үед тогтвортой хэрэглэж байсан үг юм. Манж хэлэнд адууны тамгыг заасан үг болон утга хувьсчээ.

**boduraldubasu.** “*aq-a degü kümün-lüge boduraldubasu erke omuy-iyan ülü jiyān*” (27-р мөрт) Тулгуур “*boduralduhasu*” хэмээн дөрвөлжин үсгийн бичиг мэт галиглажээ. Тэр бээр хятад бичээсийн “與人交” гэдэг үгтэй тохиролцож буйг дурдаад “харилцаж явалцах, нөхөрлөж явалцах” гэсэн утгатай бололтой гэжээ. В.М.Наделяев нарын “Древнетюркский словарь” (109 стр.)-д: *bodul-* бытъ прикрепленным, прицепленным, привязанным; *bodulmaq-* привязанность, связь, присоединение хэмээн тайлбарлажээ. Дурдан буй хөшөөний үг бол эртний түрэг хэлний энэхүү *bodu-* язгуурт үгстэй гарал нэг бөгөөд монгол хэлний үйл үг бүтээх -га дагавар, үйлдэлдэх хэвийн -*ldu* залгавар авсан үүсмэл үг гэж үзэх нь зүйтэй. Утга нь хэлхэлдэх, холболдох гэсэн үг бөгөөд хятад бичээс дэх “與人交” лүгээ үндсэндээ тохирч байна.

**gegüdel ügei.** Сэцэнцогт нарын “Монгол үгсийн язгуурын толь”-д *ᠭᠡᠭᠦᠳᠡᠯ* хэмээх үгийг *gegüt* [gü:t~gegt] гэж галиглан “юмыг санаандаа агуулахгүй гээн чадах” (1250-р тал) хэмээн тайлбарлажээ.

<sup>9</sup> *Mongyol üges-ün iγayur-un toil.*, *Sečenčoytu nayiraγulba.*, ОМАКQ. 480 т.

### Ш. Чоймаа, М. Баярсайхан

**jigtün.** Судлаачид бүгд jigtü-n < jidkü-n буюу зүтгэх гэдэг үгийн авиа тонгорч, үйл үгийн нөхцөлдүүлэн холбохын хамын –n нөхцөл авсан хэлбэр гэж үзсэн нь зүйтэй байна. Гэвч, бидний бодлоор энэ бичлэг авиа нь тонгорсон хувилбар дуудлагыг тэмдэглэсэн бус, харин энэ үгийн эртний хэлбэрийг хадгалсан, уул гарлыг нь тодотгохуйц бичлэг бололтой. В.М.Наделяев нарын “Древнетюркский словарь”-д үзвэл, эртний түрэг хэлний “jigtür-” хэмээх үг шахах, чихэх, дарах түлхэх гэсэн утгатай байна. Монгол хэлний “jigi- (жийх)” гэдэг үг үүнтэй нэг язгууртай. Мөнөөх jidkü- (зүтгэх) хэмээх үгийн язгуур нь угтаа jig- бөгөөд хүчлэн түлхэх, урагш түрэх гэсэн утга нь язгуурын ерөнхий хийсвэр утгатай нийлж байна.

**dalyan.** МНТ §208. “yeke tore setkijü jürcedei-yin qatquldu’an üdür qalqa boluqsan-u dayisun gü’ün-tür dalda boluqsan-u qaqaqsan ulus qamtutqaqsan-u butaraqsan ulus бүгүтгелдүксен тусас-un inu ...”. Энэ жишээнээс үзэхэд, дундад үеийн монгол хэлэнд dalda “далд” хэмээх үг халх, халхавч, хаалт зэрэг үгтэй ойролцоо утгатай, үгсийн аймгийн хувьд жинхэнэ нэр үгээр хэрэглэгдэж байсан нь тов тодорхой байна. Сэцэнцогтын “Монгол үгсийн язгуурын толь”-д dalda “далд” нь далдавч, халхавч, хамгаалагч гэсэн хуучирсан утгатай хэмээн зөв тэмдэглэжээ. Үгийн үндэс нь dal (дал) бөгөөд мөн тольд дурдсанаар 1.зуд шуурганаас далдалж халхлах малын пин саравч, 2. нарны ээвэр нөмөр газрыг заадаг аж. Халимагийн хэлэнд малын хашаа саравчийг “дал” гэнэ<sup>10</sup>. Манжаар халхлах, туухыг dali- гэдэг нь нэг гаралтай үг юм.

**qomūqaljayulquy-a.** (48т)- Иринчин аругай 鼓励 зоригжуулах, урамшуулах гэсэн утгат үсгээр орчуулсан байна. Монгол үгсийн язгуурын толь-д “хөшүүрхэн дурлах” гэж тайлбарласан нь уг хөшөөний дүйх хятад ханзад тулгуурласан тайлбар байна. (1079т) Энэ үг даруй хомголзох гэсэн үг мөн бөгөөд алдар хүндэд дурлах сэтгэлийг хөхиүлэн хөвхөлзүүлэх, шунуулах гэсэн утга илтгэж байна.

**teli.** 53 дугаар мөрт “qayaly-a-dur činu bii tas bayiyulbai yeke-de teli” гэжээ. Дундад эртний монгол хэлний энэ “teli” хэмээх сул үг МНТ-д нийт таван удаа гардаг. Үүнд:

§246. ele urida üge baraqdalū’a je teli ke’en soyurqaju

§256. altan jilo’a batu-da tataju ire’esü tende maqa boltuqai teli ke’ejü

§256. ö’ere maqa gü’ün-tür joriju бүкүй-түр je teli

§265. cinggis-qahan mariya qala’un arun ügüleriün je teli eyimü yeke üge ügüle’üljü

§277. debülküi toqo’an-i delegei sinaqa bolju amurli’uldaju-je teli ke’er-ün üyile batu-yi ke’elele’ei.

Хажуугийн орчуулгад нь дулдуйдан судлаачид “тийм адил, тийм байсан” хэмээн төсөөлсөн утгатай гэж үздэг.

**erütele.** 53 дугаар мөрт “uruysi-da maytayulqu-yi yaγun erütele bui tan-a” гэжээ. Энд гарч буй “erü-” гэдэг үйл үг МНТ болон сонгодог монгол бичгийн хэлний өмнөх үеийн дурсгалд цөөнгүй тохиолдох бөгөөд “зовних” гэсэн утгат үг юм. Монгол хэлний “зовох” гэдэг үйл үг эртдээ зөвхөн бие махбодоор зүдэж шаналахыг заасан үг байсан, харин сэтгэлээр зүдэх шаналахыг “эрэх (erükü)” гэдэг байсан бололтой юм. “энэлэх (enel-)” гэдэг үг энэ үгтэй нэг язгууртай байна. Хожим “эрэх (erükü)” гэдэг үгийн хэрэглээ хумигдан, зовох гэдэг үгэнд аажмаар байраа алдаж, оронд нь сэтгэл зовох гэсэн холбоо үг, эсвэл зовних гэдэг үгийг хэрэглэх болжээ. Хуучирч мартагдсан үгсийн зарим нь нэг хэсэгтээ хоршоо үгэнд, эсвэл нэлээд тогтвортой холбоо үг, хэлц зэрэгт үлдэж хэрэглэгдсээр байх явдал бий. Саган сэцэний “Эрдэнийн товч”-д: «qoyina nigen čay-tur minu amidu daki metü: qotala-yi jirγayulquy-a yaγun erükü kemen jarliy boluyad»

<sup>10</sup> Хальмг-Орс толь, ред. Муниин Бембе, Москва. 1977., 178 стр.

### III. Чоймаа, М. Баярсайхан

(Өргөө эх 41v02-03); «dur: včir dara dalai lam-a: asuru ʎomurqayad: tere ber bodi qutuγ-i jorin odquy-a yaγun erükü: ta» (Өргөө эх 82v16-17) хэмээн хоёр удаа гарч байгаагаас нь үзэхэд “юун эрэх” гэдэг холбоо үг 17 дугаар зууны үед хүртэл нэлээд хэвшмэл хэрэглээтэй байсан байна.

**jöb jügiyer.** 6 дугаар мөрд “ayan ayalan yabuju jöb jügiyer kücü öggün ulus qamulduγsan”; 27 дугаар мөрд “tariyan-u üile-yi erkilejü jöb jügiyer-iyen aman qoγolai tejigen qataγujiγad” хэмээн хоёр удаа гарч буй. Ф.В.Кливиз гуай энэ үгийг “ab adali”, “keb kejiy-e”, “sib sir-a” гэсэн шиг язгуур давтан хоршсон үг биш, харин эхний үг нь jöb (зөв) хэмээх үг гэж үзсэн нь зүйтэй байна. jüg гэдэг нь зүй, ёс гэсэн утгатай ба үйлдэхийн тийн ялгалын нөхцөл залган jügiyer гэсэн хэлбэр үүсчээ. Сонгодог монгол бичгийн хэлний өмнөх үеийн дурсгалуудад энэ үг хэдэнтээ тохиолдож байна. Тухайлбал, 1335 оны Чан Ин-жүй (Chang Ying-jiu)-гийн гэрэлт хөшөөнд “ene metü degedüs-e jüg-iyer kücü öggüged” хэмээн нөхцөлийг нь саланги бичжээ. Яваандаа jöb jüg-iyer “зөв зүгээр” гэсэн уг бүтэц, гарал утга нь мартагдан “зүв зүгээр” гэж хэлж бичих болсон байна.

Бичээсний үгийг монголчилсон Эсэнбуха бол Монголын Нууц Товчооныг сайн мэддэг, тэр цагийн монгол бичгийн хэлээр гарамгай найруулан бичих чадвартан байсан нь эргэлзээгүй байна. Тогоонтөмөр хааны үед Их Юань улсын төв мужийн зүүн гарын туслагч түшмэл асан тэр бээр хятад бичээсний үгийг орчуулахдаа үгчлэн орчуулсангүй, агуулгыг үл алдуулахын сацуу, монгол найруулгад тохируулан утгачлан орчуулжээ. Тиймээс МНТ болон 14 дүгээр зууны үеийн монгол хэл, бичгийн дурсгалуудад байдаг тэр цагийн монгол бичгийн хэлний тогтвортой үг хэллэг энд цөөн бус гардаг. Жишээлбэл:

Инд.3 дугаар мөрт. möngke tngri-yin ibegeliber yeke mongyol ulus-un qan  
МНТ §179. tengeri-de ihe'ekde'esü

Инд.4. altan beyeber ulus qamun ayalan yabuγsan  
МНТ §239. Qurdun aya ayalaqui-tur qurca bulqa bulqalduqui-tur

Инд.16. ...er-e-yi ülü jobayan ayta-yi ülü kölörgen sayibar oroju kücü öggügeber  
МНТ §239 ...ere aqta-yi ülü siryan ülü joba'an öljeitü hoi-yin irgen-i oro'ulju ireba

Инд.27. aman qoγolai tejigen  
МНТ §74. üdüр söni qo'olai teji'eba

Инд. 35. jöb es-e boluγsan-u qoyin-a ene ayan basa Ši ning ong wušin ner-e soyurqaju ögbei  
МНТ §272. qahan aqa minu jö[b] ese bolu'asu olon mongqol ulus öncirekүн

Инд. 20. čerig ayan-u üile jedkür boluyad ulus irgen toγtaγan yadaju  
МНТ §281. quru'a yo'urqa nödü'üljü jetgүjү aqu болон aqa de'ü-dece cimaliqai üge sonosba

Инд. 21. qoruyan ba yoγuryas erügүlүн nüdügүljү  
МНТ §281. quru'a yo'urqa nödü'üljү

Инд.45. öber-ün beye qad-ta ner-e ber soyurqal uridus-tur-iyen ba ong ner-e kiged soyurqayulju  
МНТ §224. beye qad-iyar oluqсан jö'eksen ere aqta

Инд.53. uruysi-da maγtayulqu-yi yaγun erütele bui tan-a  
МНТ.93. hö'elүн-еке qasar ki'et de'ü-ner inu herүjү aju üjejү bayasba



### Ш. Чоймаа, М. Баярсайхан

Эл хөшөөний бичээсэнд “нарбайг (нармайг) нэгтгэх, тэнгэрийн зоригийг дагах, дэлхийн эзэн, алтан бие, мэдлийн иргэн, улс хамах, аян аялах, зөв зүгээр хүч өгөх, дээжлэн соёрхох, эжээ хүртэл, эгүүри уртад, урьдасын язгуур, урьдасын хүүр, узуур барилдах, зэргээр өгүүлэх, зохион үүсгэх, узууртны (язгууртны) ураг, нэр өгтөх, хэрсэг мэт халхлах, шүтгэн (шийтгэн) дурдах, эрийг үл зовоон агтыг үл хөлөргөх, сайваар орох, хорт үйлсийг этэн, тустыг явуулах, нэр соёрхож өгөх, хатуу зоригт баатар зүрхт, гэрээс үг тавих, адат үйлд учрах, хатуу зоригоо үл хариулах (мятах), өвчин хүртэх, сайн нэрийг үл гутаах, гүйцээн үйлдэх, их төрийн өмнө хүч өгөх, булха-г борчих (дайсныг номхотгон дарах), цэрэг аяны үйл, бэхлэн шүтээлэлдэх, их төрийг (ёсыг) сэтгэх, биенгэдэх, үйлд түшигдэх (томилогдох, тушаагдах), бэй ташийн аялгуус (үгс), манлайн их үсэг, тэнгэрийн заяанаа гүйцэгдэх (насны тоо гүйцэх), зөв эс болох (нас барах), халханлиг, газарлиг, удаарах (дараалах), урагшид магтуулах, тэмдэгтэйгээ хүч өгөх, газар усны найр зохис, соён сургах, аман хоолой (ходоод гэдэс) тэжээх, ачийг хүндэд сэтгэх, омгоо үл заах, биеэ ариун сахих, эрүү (ял гэм) хорд үл орох, төрийн үйлд барилдах, дээш игтуриулах, үйл хадгалах(хэрэг захирах гэсэн утга), ааль нь жавхлан, тулах нэрд хүрэх, үд манагаар, уйтгаргүй үзүүлэн хүч өгөх, узуураас үзүүр хүртэл, урагшид дүр дүрс (ерийн хэв байдал) болгох, үл чадах будуу (бядуу) оюут, за хадгалсан, нөгчсөн урьдсын нэрийг байгуулах, ирэн одон явах мөр дээр, хойдсыг бээр хомголзуулахуй, улсаа сайтар зарчимлах, ойр эс халгах, сайнаа олдсон (их олон болсон), өсгөлөн урт мод, үл түридэн (саатан, торон) дэвлэх, сургаж өгсөн сүегэр (сургаал), хэрлэж сахих, суу залиг залбирах, өвдэгш (өөдөгш) сэрэх, үл уйдан барих, үүр (өнө) уртад соёрхогдох, улсын өмнө хүч өгөх, худ ураг барилдах, чин үнэнээр хүч өгөх, дайсныг халхаж хариулах (дайсныг хориглон няцаах), насад урагш зүтгэн хичээх, маш хүндэд сэтгэж явах, үгүй болох (нас барах), дотор ба гадна үл түшигдэх (дотоод гадаад хэргийн албанд томилогдох), халтирал үгүй хатгалдах (үл мятран байлдах)” гэх мэт монгол бичгийн хэлний үг хэллэг цөөнгүй. Арваад жилийн өмнө Чингис хааныг өнгөрсөн 20 дугаар зууны дэлхийн хамгийн агуу их хүнээр тодруулан, дэлхийн энтэй хаан бүлгээ хэмээн олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч байгаа билээ. Гэтэл, аль эрт 14 дүгээр зуунд, тус хөшөө чулуунд “Дэлхийн эзэн Чингис хаан” хэмээн алдаршуулжээ. Эдгээр бичгийн хэлний үг хэллэг, холбоо хоршоог утгыг нь зөв мэдрэн, өнөөгийн хэл найруулгад цаг, орныг нь олж зохистой хэрэглэвэл, бичгийн ур чадварт тустайгаас гадна, бас орчин цагийн шинэ утга ухагдахуунд оноож, нэр томъёог тогтооход ч хэрэг нь гарч болох юм. Хуучны бичгийн хэлний холбоо үгсийг гярхай ажиглан шинжилбэл, өнөө хүртэл бид олж танилгүй явсаар ирсэн үгзүй, үг бүтэх ёс, үгийн утга судлалд холбогдол бүхий олон сонин зүйлийг нээн илрүүлэх боломжтой юм.

Эцэст онцлон тэмдэглэхэд, Ф.В.Кливиз гуайн монгол хэл, монгол бичгийн дурсгалыг тусгайлан шинжилсэн олон арван бүтээл нь тухай тухайн сэдвээр гарсан судалгааны дотор шилдэг нь болж чадсан юм. Ф.В.Кливизийн сурвалж судлалд гараагаа эхэлсэн бүтээлийн нэг болох Инду вангийн хөшөөний бичээсийн судалгаа нь уг дурсгалын анхны атлаа, хамгийн дорвитой бүрэн судалгаа болсон гэдгийг баттай хэлэх нь зүйтэй. Хожмын судлаачдын бүтээлийг үзэхэд, чухамдаа Ф.В.Кливиз гуайн зохиол үндсэн нуруу, тулгуур нь болсоор ирсэн нь тодорхой харагдаж байна.

Жич, хөшөөний бичээсийн галиг урьд гарсан боловч, зарим үгийг бид өөрөөр уншсан зүйл байгаа тул галиг, хөрвүүлгийг хойно хавсаргав.

Индү вангийн хөшөөний монгол бичээсийн галиг (1362)

- I. yeke mongyol ulus-tur
- II. jrly-iyar si ning
- III. ong indü-de
- IV. bayiyuldaysan bii tas buyu

- 01. jrly-iyar dai ön yeke mongyol ulus-un si ning ong indu-de bayiyuldaysan bii tas buyu.
- 02. jrly-iyar jungsu šingun samjing ui-suu-yi bii tas-un ayalγus-i joqiyayulbai. ting gui gung šiken dai keuši jang ki-yi bičigülbei. jungšu šingun yiučing činging bai-yi manglai-yin üsüg-i bičigülbei. jungšu šingun soočing esenbuq-a-yi mongyolčilan orčiyuluyad uiyurčilan bičigülbei.
- 03. möngke tngri-yin ibegeliber yeke mongyol ulus-un qan-i narbai-yi nignedkegölün jayaydaysabar delekei-yin ejen
- 04. činggis qayan tngri-yin joriy-i dayan ümedü yajar-ača yeke üile-yi bütügen altan beyeber ulus qamun ayalan yabuysan dötüger on-dur uiyudun qan inu barčuy ard iduy-qud medelün irgen-iyen abuyad oroju
- 05. suu-tu
- 06. činggis qayan-i dayan barayun eteged sartayčın ayan ayalan yabuju jöb jügiyer küčü öggün ulus qamulduysan-u šiltayabar olan-ča dotun-a soyurqaydaysan ajuyu. qoyin-a qad qad-un čay-tur ber iduy-qud-un sayibar oroju ulus-un emün-e küčü öggügsen jerge-yi inü degejilen soyurqaju anda
- 07. quda uruy barilduysan-ača ejiy-e kürtele egüri urtu-da soyurqaydaqu siltayan kemebesü iduy-qud öber-ün tüšimel-iyer-iyen iregei-üdügüi üiles-i urida böged uqaju tngri-yin joriy-i dayan yabuysabar bolbai j-a. edüge jungsu šingun bingjang oron-u uridus-un ujayur barilduju iregsen-i jergeber
- 08. ögüley-e. ji jing qorin qoyaduyar on dörben sar-a-dur
- 09. jrly-iyar bi ui suu-yi bingjang oron-u uridus-un kegür-tür bayiyuldaqu bii tas-un ayalγus-i joqiyatuyai kemegsen-dür joqiyar egüskejü dayusuyai-üdügüi-e basa gemčas bičig-iyer duradqar-un degedüs-e oron-u čing ünen-iyer küčü öggügsen jerge-yi uqabasu uridus-a inu ong ner-e nemegdekü bui kemen
- 10. jungsu šingun noyad-iyar öčigülbesü ečige inü indü-de si ning ong ner-e soyurqaju ögbei. mön on jiryuyan sara-dur basa bi ui suu-yi bii tas-un ayalγus-i joqiyayulun janki-bar bičigülün činging bai-bar manglai-yin yeke üsüg-i bičigülün esenbuq-a-yi mongyolčilan orčiyuluyad bičigültügei kemen
- 11. jrly boluysan-u siltayabar bi ui suu ulam-ča bolγabasu bingjang oron ujayur barayun eteged bis baliy-a nuntuy<sup>11</sup>-tu ujayur-tan-u uruy ajuyu. elinčüg inü qar-a uiyud-un yajar-a бүкүй-dür iduy-qud-ta qalqanliy totoy ner-e ögtejü noyalan yabuysan ajuyu. qalqan kemebesü keriske metü yajiyu dayisun-i
- 12. qalqalaju qariyulqu-yi kemeyü. totoy kemebesü ötögüs-ün quiloγu ner-e inü ajuyu.
- 13. suu-tu

<sup>11</sup> Орчин цагийн монгол хэлэнд “нутаг” хэмээх үгийг МНТ-д тогтвортой “нунтуг” хэмээн бичсэн байдаг. Мөн Могол хэлэнд ч тэгж хэлдгийг Зириний гар бичмэлээс бид мэддэг. Монгол бичгээр ч ийн бичдэг байжээ.

### III. Чоймаа, М. Баярсайхан

14. činggis qayan tür-ün ulus qamun yabuqui-dur mön qalqanliy qar-a totoy iduy-qud-tur südkün<sup>12</sup> duradqaju
15. suu-tu
16. činggis qayan-u er-e-yi ülü jobayan ayta-yi ülü kölürgen sayibar oroju kücü öggügseber soyurqaydaju irgen jasadulun tüšigdebesü egenegte degedüs-e açılan kücü ögkü-yi erkilen ulus-a qour-tu üiles-i eten tus-a-tu-yi yabuyulusabar olan-a maši sayišiyaydaysan ajuyu ene ayan imayi wungšinglar-un
17. ši-sen daiwu šamši dingču qing-jungsu šingun yiučing wan yang gün gung ner-e soyurqaju öggüged gergei inü tayai qunčui tuyan qus neretü uiyud-un yajar-a бүкүй-дүр iduy-qud-ta ana tegrim ner-e ögtegsen ajuyu. ene ayan wan yang gün wušin ner-e soyurqaju
18. ögbei. ebüge inü ataibuq-a qatayu joriy-tu bayatur jirüke-tü бүкүй-ийн šiltayabar ada-tu üile-dür uçirbasu ber qatayu joriy-iyen ülü qariyulun aysan ajuyu. qoyin-a elinčüg inü qar-a yiučing ebedčün kürtejü aljangyu boluysan-dur köbegüd-iyen iregüljü geriyes üge talbir-un
19. ta ülü ontodayidan nasuda uruyši jigtün kičigen yabuqu-yi erkileged uridus-un sayin ner-e-yi büü yutuyadqun kemegdegsen-ü tula mön ataibuq-a bingjang üileddekü ele<sup>13</sup> üiles-i ülü üleden čidaqui-ča güyičegen üiledügsen ajuyu. qoyin-a duw-a busm-a-tan
20. köbegüd bulq-a bolbasu mön ataibuq-a qučqar iduy-qud-i dayan yeke törö-yin emün-e kücü öggün yabuyad bulq-a-yi borčiysan-u qoyin-a basa uiyud-un yajar-a bis-baliy-tur čerig ayan-u üile jedkür boluyad ulus irgen toytayan yadaju tumtuyaljaysan-dur
21. qar-a qočo-dur negüjü ireged qoton balayad nemen bosqaju qoruyan ba yoyuryas erügülün nüdügöljü ulus-iyar-iyen bolju yača joriy-iyar qoton[=qotan] bekilen šitügeleldün бүкүй-дүр duv-a-tan köbegüd arban qoyar tümed čerigüd-iyer qoton-u jaqada kürcü bürin qadqulduqui-dur
22. mön ataibuq-a үкүкүйбен ülü talyan yeke törü-yi sedkijü beyenggedün šitügeleldün qadqulduyad olan-ča uruyši yabuju temdegtey-e kücü öggügsen-ü šiltayabar imayi itegeltü tuy-tu čerigüd-ün noyan bolyan tüsiged darqan ner-e ber öggügsen ajuyu. qoyin-a iduy-qud
23. deger-e ayuljan yarču irebesü mön ataibuq-a ayruy-iyen[=ayuru-yen] abuyad dayan ireküi-dür jobalang-ud-i ülü talyan jayur-a berke čöl-nügüd-i tuyuluyad yungjang-dur kürbesü yajar usun-u nayir joqis-tu amun künesün elbeg-tü-yin tula doturayan oyisiyaju orosin yungjang-a
24. nuntuylaysan ajuyu: mön ataibuq-a jöb es-e boluysan-u qoyin-a angq-a urida ya jung daiwu sangon-iyar šiken či keuši ner-e nemejü öggüged darui-dur basa ling wung daiwu yamju šingun samjing bolayad udayaran basa kü ši san daiwu samši šingun yiučing ner-e
25. nemejü ögčügü ene ayan basa yunglu daiwu yamju šingun bingjang jingši juu gui jui wung šin-gui gung ner-e nemejü öggüged jöb es-e boluysan gergei inü šumay-a qadam eke inu tayai qunčui-da soyurqaju öggügsen ner-e-yin yosuyar ner-e nemejü ögbei. qoyin-a šin gui tai wusin
26. ner-e ögčügü. köbegüd inü yurban ajuyu. yekemed inü terkün-buq-a, ded inü alinbuq-a yutuyar inu indü kemebesü bingjang oron-u ečige inü ajuyu. mön indü esen бүкүй-дүр-

<sup>12</sup> Хөшөөний хятад ханзанд 寔輔(shí fū) хэмээсэн бөгөөд утга нь “тавих, байрлуулахад туслах” ажээ. Түүний монгол орчуулгад нь “сүтгэн” хэмээн гарч буй. Энэ үгийг “sidkün” хэмээх үгийн авиа ижилссэн хэлбэр гэж үзэв. “sidke-” (шитгэ-, шийтгэ-) хэмээх нь “ямар нэгэн хэрэг явдлыг шийдвэрлэн тогтоох, гүйцэтгэх, албан хэргийг төлөвлөх, эмхлэн цэгцлэх” гэсэн эртний утгатай. Орчин цагийн монгол хэлэнд “шийтгэх” хэмээх үгийн утга нь гол төлөв ял төлөвлөх мэтэд хэрэглэх төдий болжээ. Мостэартын “Ордос толь” бичигт “Монголын алба шийтгэдэг газар, төрийн үйлсийг шийтгэх” гэх мэт жишээ тохиолдож байгаа нь хэргийг явуулах, цэгцлэн шийдэх, төлөвлөн тогтоох хэмээсэн утгаар л буй.

<sup>13</sup> Ф.В.Кливиз ken, Иринчин ele, Тулгуур ele хэмээн тус тус галиглажээ.

Ш. Чоймаа, М. Баярсайхан

- iyen isü<sup>14</sup> köbegüd-iyen soyun suryar-un ta köbegüked nasun öcügüken ali-ba jobalangud-i es-e
27. üjebei. tariyan-u üile-yi erkilejü jöb жүгийер-iyen aman qoyolai tejigen qatayujiyad čidaquiča sayin üile üiledčü mayui üile büü böged üiledүдкүн. ečige eke-de törүгүлдегсен ба теjiyегдегсен аči-yi masi [kü]ндү-de sedkijü yabuяad aq-a degü kümün-lüge boduraldubasu erke
28. omuy-iyen ülü jiyān öber-eče dorodus öčүked-i büü basumjilan öber-ečegen erdem-tü sayid-luy-a aq-a degü barildu. ker-be
29. degedüs-e soyurqaydaju oralayuldabasu beyeben ariyun-a saqiju kičigen uruysi jigtün yabuяad čing ünēn joriy-iyar degedüs-e açilan küčü ögküiben erkilen irgen-i öber-ün köbegün šibayun metü tayalaju yabubasu ta eregü qour-tur ülü oroyad mun-a mun-a qoyin-a
30. sayin ner-e tanu egüride aldarsiyuldamui j-a. edeger üges kemebesu tan-a uqaydaqu bui kemegsen ajuyu. mön ši ning ong indü egenegte čing ünēn joriy-iyar beye-yin açan<sup>15</sup> bolyan erkilejü yabuqu-yin tula яajarliy ele irgen imayi күндүлен айсан аjuyu. qoyin-a
31. ji-šün qoyaduяar on qubi sara-yin arban dörben-e ebedčin күртеjü jöb jirun nasun-dur-iyar tngri-yin jayayan-a güičegdebesü yasun inu yungčang-un jegün eteged gün mören-ü qijayar-a orošiyuluysan ajuyu. imada angq-a urida wung күn daiwu libu-
32. yin langjung ner-e soyurqaju öggüged darui jung šün daiwu libu-yin šilang ner-e nemeju öggüged udayaran basa ga yi daiwu libu-yin čangšu ner-e nemeged basa ši dii daiwu šamsi šingun yiučing bolуyad basa yunglu daiwu яamju šingun bingjang bolуyad basa gi gui gung
33. ner-e nemejü ögčүgü. ülü udan darui-dur basa si ning ong ner-e soyurqaju öggüged qanlim-ön-ü noyad-iyar sitiü kemekü silüg-tü
34. sön bičigүljü öggüged si ning ong-un wušin inu buyanjin kemebesü göden ejen-ü or-a sayuysan ging ong-un bayši uqari-yin ökin inü ajuyu. angq-a urida wungšinglar-un dai qing ken gün bolyan: nöğüge-de wan yang gün gün ner-e öggüged yutuяar-
35. -ta gün wušin ba gün tai wušin: gi gui tai wušin ner-e öggüged jöb es-e bolуysan-u qoyin-a ene ayan basa ši ning ong wušin ner-e soyurqaju ögbei. mön si ning ong tai wušin ji jing arban naimaduяar on jiryуan sara-yin
36. arban dörben-e jöb dalan dolуan nasun-dur-iyar ebedčin-iyer ügei bolуyu: imada-ča jiryуan köbegüd törүgsen ajuyu: yekemed inü bolodbuq-a, ded inü jungšu šingun bingjang oron, yutuяar inu buyan, dötүger inü bayan suu jiu-yin tungji bolуysan ajuyu: tabduяar inu
37. tuylyu edүged-tür isin-a čölge-yin sunggon, jiryuduяar inu derbis čүmüi ön-ü sem ön büi. ači köbegün inü tabun ajuyu. buq-a яamju čölge-yin wubun: manglaibuq-a яamju gongwu: bayiju qing yamši ön-ü tüşikün, yolbuq-a gem siu gui si wuu-yin samgun
38. jamuči, mön bingjang oron kemebesü ši ning ong-un ded köbegün inü ajuyu. tür-ün üile-dür barildur-un jišing šešin-če dai sinungsi-yin gingly: ü tay-yin gemča üši, libu-yin ön uilang bingbu-yin langjung bolуyad mön bu-yin šilang iyuriyulju
39. yabuяad quu nam jesi geng dung yurban dau lemwangsi-yin wuši tüşigdeged dayidulu-yin darуyači jungsu soo si langjung, libu čangsu singun samyi daidu liušu, qarajang šingun samjing, sonjing ön-ü tungji, basa daidulu-yin darуyači üši tay-yin jišu, čүmui ön-ü tungji,
40. jungsu šingun yiučing bolуyad darui-dur degegši iyuriyulju bingjang bolyan tüşigdeged

<sup>14</sup> Энэ үгийг Ф.В. Кливиз “nasu”, Иринчин “asu” хэмээн галигласан нь үсгийн махбодын хувьд аль аль нь боломжтой атал, утга нь огт авцалдахгүй байна. Бидний бодлоор энэ үг нь дараагийн хөвгүүд хэмээх үгийн тодотгол байх магадлал илүү бөгөөд магадгүй “isü” гэж галиглах үг байж болох юм. Өнөө хир судлаачдын үзэж ашиглаж буй гэрэл зургаас энэ мэт үгсийг нарийвчлан хянах боломж бас хязгаартай байгааг тэмдэглэх хэрэгтэй. Хэрвээ “isü” (ис) гэж уншвал энэ нь идэр өсвөр гэсэн утгатай тодотгол болно.

<sup>15</sup> Энэ үгийг А.Мостаэрт ‘ačiyān’, Ф.В. Кливиз ‘ačan’, Дов ‘ejen’ гэж унших бололтой гэжээ. Профессор Иринчин ‘ačan’ гэж уншаад 將持 гэж тайлбарлажээ. Тулгуур мөн ачаа гэдэг үг гэж үзсэн буй.

### Ш. Чоймаа, М. Баярсайхан

udayaran basa yurban-ta uyelen degegši iyhuriyulun soyurqaydaju jungšu šingun aqalaqu bingjang tüsigdeged yin sing yunglu daiwu sangon ögtejü yabuyad darui-dur basa gimsi gonglu daiwu

41. sangon nemejü öggüged qas nisan ber subutu jisün altan büs-e soyurqaydabai. bi j-e ui suu bingjang oron-luy-a nigen yamun-dur egüri od qamtu neyite soyurqaydaju üile qadayalan tüsigdegsen-če bolyabasu ayali inu jibqulang deger-e oyin[=oyun] inugegegen ulus-un yeke
42. üile-dur dadmayai bükü-yin siltayabar dotur-a ba yadan-a üile-dur tüsigdegsen-dür jöb yabuyasan sayin ner-e inü olan-a temdegtey-e uqaydaysabar
43. suu-tu
44. qayan soyurqaju imayi tulqu ner-e-dür kürgeged ulus-un yeke üile-yi qadayalayulju üde manayar kegüdel ügei
45. altan čirai-dur oran yarun yabuju asaraydayad öber-ün beye qad-ta ner-e ber soyurqal uridus-tur-iyen ba ong ner-e kiged soyurqayulju kemebesü yağça nigen ödür-ün kičigel qatayujil-iyar güyičegsen busu egenegte uyidqari ügei üjügülen küčü öggügseber eyin soyurqaydabai j-a.
46. qayan ejen manu oron-i ene metü belgetey-e soyurqan küčü öggügseber jerge-yi inü ujayur-ča üjügür-tur kürtele bičigüljü bii tas-tur čoyulyayulqu siltayan kemebesü uruyšida duri dürsü bolyaju olan tüsimel-i qomuylajayulqu-yin tula buyu j-a. bi öčügüken boyol tüsimel ui suu ülü čidaqu budayu oyitu
47. kümün bögetele urida tobčiyen j-a qadayalaysan-ača siltayalan yadaju ayuyad emiged<sup>16</sup> bii tas-un ayalyus-i šilüg selte joqiyaju nögdögsen uridus-un anu ner-e-yi iren odun yabuqu mör deger-e bayiyulqu šiltayan kemebesü
48. degedüs-ün күндү аči-yi büširen sedkijü edügülün aldaršiyuluyad qoyidus-i ber qomuylajayulquy-a buyu j-a
49. balar-ča<sup>17</sup> uiyud-un qan inu bis baliy-a orosin sayun ajuyu: berkešiyel ügei bayatur er-e törüjü: bekilejü ulus-iyen sayitur jarčimlajuyu. yajiyu dayisun-i qalqalaju oyir-a es-e qalyaysan: qaltaril-ügei qadqulduju sayiban oldaysan: qadayalaysan mingyan-iyen abuyad qamil-a talbiysan:
50. qayan-a küčü öggün negjü yungjang-a nuntuylaysan: ösküleng urtu modun uryubasu ele oi-dur: ujayur inu gün-e ündüsüleyü ötegen-ü küi-dür: ülü türidün debülbesu bul[a]y nasuda urusqal-dur: urusuyad nayursiju ülü širgiyü ali-ba čaj-tur:
51. qayan-ča ši-ning ong ner-e soyurqaydaysan indü: qaldaju köbegüd-iyen bariyuluysan ajuyu: čegejiben nimtu: yağça oron-u küčü öggügseber-iyer jöb inü күндү: qamuy бүгүдегер нерес-iyen bičigülbei bii tas-tur qamtu -:- köbegüd uruy činu qotolayar: kereglegdejü jergeber noyalabai: kerlejü jasağ-ča beyes-iyen saqiquibar:
52. ken-e ber mayui es-e kemegdebei -:- suryaju ele öggügseber söyüger-i činü:

<sup>16</sup> Профессор Ф.В.Кливиц бээр “nemiged” гэж галиглаад “emiyegeed” гэдэг үгийн эртний хэлбэр гэжээ.

<sup>17</sup> Ф.В.Кливиц толгой холбосноор бодож “beler-če” хэмээн галиглажээ. Тулгуур мөн “балар” гэдэг үг гэсэн боловч, “beler” гэж галиглав.

### Ш. Чоймаа, М. Баярсайхан

- söni ödür saqiju es-e umurtabai:  
suu jali-yi jalbariju yabuysabar:  
soyurqal kürtebei ükügsen ba amidu-dur:  
γadan-a gün mören neretü šiltegen-dür-i:  
γayiqamšiy-a bosqaju amu kegür-ün ger-i:  
53. qayan-u jrly-i saisang-ud-ta kürtegsen-dür-i:  
qayaly-a-dur činu bii tas bayiyulbai yeke-de teli -:-  
urtu-da üiledügsen-iyer sayin udq-a:  
uruγ-iyar manduba. öbedegši seren<sup>18</sup>:  
ülü ele uyidun baribasü sedkil-iyen γayča:  
uruysi-da maytayulqu-yi γayun erütele bui tan-a -:-  
54. ji jing qorin qoyadyar on bars jil arban sara-yin arban qoyar-a bayiyulbai -:-  
sadu sadu -:-

#### Индү вангийн гэрэлт хөшөөний бичээсийн хөрвүүлэг

- I Их Монгол Улсад  
II Зарлигаар Си нин  
III Ван Индү-д  
IV Байгуулдсан бэй таш буюу

1. Зарлигаар Дай ван Их Монгол улсын Си нин ван Индү-д байгуулдсан бий таш буюу.
2. Зарлигаар жүншү синьгүнх самжин Уй Суу-г бий ташийн аялгуусыг зохиогуулбай. Тин гүй гүн шихэнх дай гүүш Жан Жи-г бичүүлбэй. Жүншү синьгүнх ючин Чингин бай-г манлайн үсгийг бичүүлбэй. Жүншү синьгүнх саочин Эсэнбуха-г монголчлон орчуулаад уйгурчилян бичүүлбэй.
3. Мөнх тэнгэрийн ивээлээр Их Монгол улсын ханыг нарбайг (нармайг) нэгтгүүлэн заяагдсаар дэлхийн эзэн
4. Чингис хаан тэнгэрийн зоригийг даган, умард газраас их үйлийг бүтээн алтан биеэр улс хаман аялан явсан дөтгөөр онд Уйгудын хан нь Барчуг Ард Идуг куд мэдлийн иргэнээ аваад орж
5. Суут
6. Чингис хааныг даган баруун этгээд Сартагчин аян аялан явж, зөв зүгээр хүч өгөн, улс хамалдсаны шалтгаагаар олноос дотно соёрхогдсон ажгуу. Хойно хаад хаадын цагт бээр (цагт ч) Идуг куд-ын сайваар орж, улсын өмнө хүч өгсөн зэргийг нь дээжлэн соёрхож, анд худ ураг барилдсанаас, эжээ хүртэл (эдүгээ хүртэл) үүр (өнө) уртад соёрхогдох шалтгаан хэмээвээс Идуг куд өөрийн түшмэлээрээ ирээдүйн үйлсийг урьд бөгөөд ухаж, тэнгэрийн зоригийг даган явсаар болбай за. Эдүгээ жүншү синьгүнх бинжан Ороны урьдсын (дээдсийн) узуур барилдаж ирснийг зэргээр
8. өгүүлсе. Жи нин хорин хоёрдугаар он дөрвөн сард
9. зарлигаар би Уй суу-г бинжан Ороны урьдсын хүүрт байгуулдах (байгуулагдах) бэй ташийн аялгуусыг зохиотугай хэмээсэнд, зохион үүсгэж дуусаагүйеэ , бас гэмчас бичгээр дуртгаруун (дуртгахдаа), дээдсээ Ороны чин үнэнээр хүч өгсөн зэргийг ухваас, урьдсаа нь ван нэр нэмэгдэх буй хэмээн
10. жүншү синьгүнх ноёдоор өчүүлбээс, эцэг нь Индү-д Си нин ван нэр соёрхож өгвэй.

<sup>18</sup> Ф.В.Кливиз öbedegsi sayča, Ирнчин übetegši saqja, Тулгуур übetegši saqča хэмээн тус тус галигласныг бид öbedegsi seren гэж унших нь зүйтэй гэж үзэв.

### Ш. Чоймаа, М. Баярсайхан

Мөн он зургаан сард бас би Уй суу-г бий ташийн аялгуусыг зохиогуулан, Жанжигар бичүүлэн, Чингинбай-гаар манлайн их үсгийг бичүүлэн, Эсэнбуха-г монголчлон орчуулаад бичүүлтүгэй хэмээн

11. зарлиг болсны шалтгаагаар би Уй суу улмаас болговоос, бинжан Орон узуур баруун этгээд Бишбалыкаа нутагт узууртны (язгууртны) ураг ажгуу. Элэнцэг нь Хар уйгудын газраа бүхүйд, Идуг куд-ад Халханлиг тотог нэр өгтөж, ноёлон явсан ажгуу. Халхан хэмээвээс хэрсэг мэт гажуу дайсныг
12. халхалж хариулахыг хэмээюү. Тотог хэмээвээс өтгөсийн гүйлогу нэр нь ажгуу.
13. Суут
14. Чингис хаан төрийн улс хаман явахуйд мөн Халханлиг хар тотог Идуг-кудад шүтгэн (шийтгэн) дуртгаж,
15. Суут
16. Чингис хааны эрийг үл зовоон агтыг үл хөлөргөн сайваар орж хүч өгсөөр соёрхогдож, иргэн засуулан түшигдвээс эгнэгт дээдсээ ачлан, хүч өгөхийг эрхилэн улсаа (улсад) хорт үйлсийг этэн (болин), тустыг явуулсаар олноо маш сайшаагдсан ажгуу. Энэ аян имайг (түүнийг) унсинларуун
17. сы шэнь дай у Шамси динчү цин жүншү шиньгүнь ючин Вань Ян гүнь гүн нэр соёрхож өгөөд, гэргий нь Тагай гүнжүй Туган Кус нэрт Уйгудын газраа бүхүйд Идуг куд-ад Ана тэгрим нэр өгтсөн ажгуу. Энэ аян Вань Ян гүнь Ушинь нэр соёрхож,
18. өгөв. Өвөг нь Атайбуха хатуу зоригт баатар зүрхт бүхүйн шалтгаагаар адат (зовлонт, түгшүүрт) үйлд учирваас бээр, хатуу зоригоо үл хариулан (няцаан) агсан ажгуу. Хойно элэнцэг нь Хар ючин өвчин хүртэж, алжанга (ядруу) болсонд хөвгүүдээ ирүүлж, гэрээс үг талбируун,
19. та үл онтгойдон (омтгойдон), насад урагш зүтгэн хичээн явахыг эрхилээд, урьдсын сайн нэрийг бүү гутаадхун хэмээсний тул, мөн Атайбуха бинжан үйлдэх л үйлсийг үл үлдээн, чадахуйгаас гүйцээн үйлдсэн ажгуу. Хойно Дуува Бусма-тан
20. хөвгүүд булха болбоос мөн Атайбуха Хочхар идуг куд-ыг даган их төрийн өмнө хүч өгөн яваад булха-г борчсоны (дайсныг номхотгон дарсны) хойно бас Уйгудын газраа Бишбалыкт цэрэг аяны үйл зэтгэр болоод, улс иргэн тогтоон ядаж тумтгалзсанд,
21. Хара хожо-д нүүж ирээд хот балгад нэмэн босгож, хороо (хүрээ) ба югургас (тоосгон хана хэрмүүд) эрүүлэн (малтуулан) нүдүүлж, улсаараа болж, гагц зоригоор хот бэхлэн шүтээлэлдэн бүхүйд Дуува-тан хөвгүүд арван хоёр түмэд цэргүүдээр хотны захад хүрч бүрэн(цөм) хатгалдахуйд,
22. мөн Атайбуха үхэхээ үл далган (халхлан, бэрхшээн) их төрийг сэтгэж, биенгэдэн шүтээлэлдэн, хатгалдаад олноос урагш явж, тэмдэгтэйеэ хүч өгсөний шалтгаагаар имайг (түүнийг) итгэлт тугт цэргүүдийн ноён болгон түшээд, дархан нэр бээр өгсөн ажгуу. Хойно Идуг куд
23. Дээр уулзан гарч ирвээс мөн Атайбуха аругаа (ауругаа) аваад даган ирэхүйд, зовлонгуудыг үл далган зуур бэрх цөлүүдийг туулаад Юнчан-д хүрвээс, газар усны найр зохист амуу хүнс элбэгтийн тул, дотроо ойшоож оршин Юнчанаа
24. нутагласан ажгуу. Мөн Атайбуха зөв эс болсны хойно, анх урьд я жун дай-у сангон-аар сикэн жи гүүш нэр нэмж өгөөд, даруйд бас жин ун дай-у Гамжу шиньгүнь самжин болгоод удааран (дараалан) басхүү сы шань дай у Шамси шиньгүнь ючин нэр
25. нэмж өгчүхүй. Энэ аян бас юнлу дай-у Гамжу шиньгүнь бинжан жинши жао гүй жүй ун шинь гүй нэр нэмж өгөөд зөв эс болсон (нас нөгчсөн) гэргий нь Шумага, хадам эх нь Тагай гүнжү-д соёрхож өгсөн нэрийн ёсоор нэр нэмж өгвэй. Хойно Шинь гүй тай усинь нэр өгчүхүй. Хөвгүүд нь гурван ажгуу. Ихмэд нь Тэркүн буха, дэд нь Алинбуха, гутгаар нь Индү хэмээвээс бинжан Ороны эцэг нь ажгуу. Мөн Индү эсэн бүхүйдээ исү хөвгүүдээ

### Ш. Чоймаа, М. Баярсайхан

- соён сургаруун (сургахдаа), та хөвгүүхэд (та нар бяцхан хөвгүүд) нас өчүүхэн аль ба зовлонгуудыг эс
27. үзвэй. Тарианы үйлийг эрхэлж зөв зүгээрээ ам хоолой (ходоод гэдэс) тэжээн хатуужаад, чадахаас сайн үйл үйлдэж, муу үйл бүү бөгөөд үйлдэхүн (үйлдэгтүн). Эцэг эхэд төрүүлдсэн ба тэжээгдсэн ачийг маш [хү]ндэд сэтгэж яваад ах дүү хүн лүгээ бодролдвоос, эрх
28. омгоо үл заан, өөрөөс доордос өчүүхэдийг бүү басамжлан, өөрөөсөө эрдэмт сайд лугаа ах дүү барилд. Хэрвээ
29. дээдсээ соёрхогдож орлуулдваас, биеэ ариунаа сахиж, хичээн урагш зүтгэн яваад чин үнэн зоригоор дээдсээ ачлан хүч өгөхөө эрхлэн иргэнийг өөрийн хөвгүүн шувуун мэт таалж явбаас та эрүү (ял зэм) хорд үл ороод мунаа мунаа<sup>19</sup> хойно,
30. сайн нэр тань үүрд алдаршуулдмуй за. Эдгээр үгс хэмээвээс танаа ухагдах буй хэмээсэн ажгуу. Мөн Си нин ван Индү эгнэгт чин үнэн зоригоо биеийн ачаа болгон эрхилж явахын тул, газарлиг эл иргэн имайг (түүнийг) хүндлэн агсан ажгуу. Хойно
31. Жи шүнь хоёрдугаар он, хувь сарын арван дөрвөнөө өвчин хүртэж, зөв жаран насандаа тэнгэрийн заяанаа гүйцэгдвээс яс нь Юнчан-гийн зүүн этгээд Гүн мөрний хязгаараа оршуулсан ажгуу. Имад (түүнд) анх урьд ун хунь дай-у Либу
32. -гийн ланжун нэр соёрхож өгөөд даруй жун шүнь дай-у Либу-гийн шилан нэр нэмж өгөөд удааран (дараалан) бас га йи дай-у Либу-гийн чаншу нэр нэмээд бас си дий дай-у Шамси шиньгүн ючин болгоод, бас юнлу дай-у Гамжу шиньгүн бинжан болгоод, бас Жи гүй гүн
33. нэр нэмж өгчүхүй. Үл удан даруйд бас Си нин ван нэр соёрхож өгөөд, Ханьлим ваны ноёдоор шитиу хэмээх шүлэгт
34. сөн<sup>20</sup> бичүүлж өгөөд, Си нин вангийн усинь нь Буянжин<sup>21</sup> хэмээх Гэдэн эзний ор суусан Жин вангийн багш Ухари-гийн охин нь ажгуу. Анх урьд унсинларуун, Дай цин хэнь гүн болгон: нөгөөд Вань ян гүн гүн нэр өгөөд, гутгаар
35. -т Гүн усинь ба Гүн тай усинь: Жи гүй тай усинь нэр өгөөд зөв эс болсны хойно, энэ аян бас Си нин ван усинь нэр соёрхож өгвэй. Мөн Си нин ван тай усинь Жи жин арван наймдугаар он зургаан сарын
36. арван дөрвөнөө зөв (яг) далан долоон насандаа өвчинөөр үгүй болжухуй. Имадаас (түүнээс) зургаан хөвгүүд төрсөн ажгуу. Ихмэд нь Болдбуха, дэд нь жүншү шиньгүн бинжан Орон, гутгаар нь Буян, дөтгөөр нь Баян суу жү-гийн тунжи болсон ажгуу. Тавдугаар нь
37. Туглуг эдүгээдэд Исина чөлгэ-гийн сунгон, зургадугаар нь Дэрбис чүмүй өнь-ий сэм өнь буй. Ач хөвгүүн нь тав ажгуу. Буха гамжу чөлгийн убунь, Манлайбуха Гамжу гүн-у, Байжу цин ямши вангийн өнь-ий түшихүүн<sup>22</sup>, Ёлбуха гэм сю гүй сы у-гийн самгүн
38. Жамучи. Мөн бинжан Орон хэмээвээс Си нин ванийн дэд хөвгүүн нь ажгуу. Төрийн үйлд барилдруун (барилдахдаа): жишин шэшин-ээс дай синунсы-гийн гинли: У тай-гийн гэмча уши, Либу-гийн өнь уйлан бинбу-гийн ланжун болоод, мөн бу-гийн шилан игтуриулж<sup>23</sup>
39. яваад Цао нам жэсы гэн дун гурван дау лэмвансы-гийн у-сы түшигдээд (томилогдоод),

<sup>19</sup> Иринчин абугай “мон-а мона” хэмээн галиглаад удаан гэсэн утгаар орчуулжээ. Энэ нь хятад орчуулгыг дагасан бололтой. Уг үг нь “мөн үүнээс хойно” хэмээсэн утгатай болохыг эрт, дунд үеийн баримт төдийгүй Алтай хэлний баримтаар ч нутлагддаг. Эртний Уйгур хэлний баримтад “muna (вог!), munča (столько), munčulaju (таким образом), munda (здесь), munday (такой), munta (здесь, в этом), muntada (после, этого)” хэмээн тохиолдох бөгөөд “МНТ”-д ч мөн адил баримт буй. [С.Е.Малов “Памятники древнетюркской письменности” М-Л, 1951, 400-401-р тал.]

<sup>20</sup> “hsüan” хэмээх хятад үгийн монгол бичлэг.

<sup>21</sup> Энэ нь Ороны ээжийн нэр бөгөөд “буян” гэдэг үгэнд эм хүйст нэрэнд залгадаг “жин” дагавар залган бүтжээ.

<sup>22</sup> Түшмэл, түшээ гэсэнтэй ойролцоо утгат үг.

<sup>23</sup> игтуриулах- iyturiyulqu, ноён зэрэг тушаалыг дэвшүүлэхийг ийн хэлж байжээ.



### Ш. Чоймаа, М. Баярсайхан

Дайдулу-гийн даргач жүншү сао сы ланжун, либу чаншу, синьгүнъ сам-йи Дайду люшү, Харажан синьгүнъ самжин, Сөньжин өнь-ий тунжи, бас Дайдулу-гийн даргач Үши тай-гийн жишү, Чүмүй өнь-ий тунжи,

40. жүншү синьгүнъ ючин болоод даруйд дээш игтуриулж, бинжан болгон түшигдээд, удааран (дараалан) бас гурвантаа үелэн дээш игтуриулан соёрхогдож, жүншү синьгүнъ ахлах бинжан түшигдээд, инь син юнлу дай-у саньгүнъ өгтөж яваад, даруйд бас гимши гүнлу дай-у
41. саньгүн нэмж өгөөд хас нишан бээр субуту<sup>24</sup> зүсэн алтан бүс соёрхогдвой. Би зэ Уй суу бинжан Орон лугаа нэгэн яаманд үүр од (олон он) хамт нийт соёрхогдож, үйл хадгалан түшигдсэнээс болговоос, ааль нь жавхлан дээр, оюун нь гэгээн, улсын их
42. үйлд дадамгай бүхүйн шалтгаагаар дотор ба гадна үйлд түшигдсэнд, зөв явсан сайн нэр нь олноо тэмдэгтэйеэ ухагдсаар,
43. Суут
44. хаан соёрхож имайг (түүнийг) тулах нэрд хүргээд улсын их үйлийг хадгалуулж, үд манагар гээгүүдэл үгүй
45. алтан царайд орон гаран явж асрагдаад, өөрийн бие хад(бие хаа-гийн олон тоо)-д нэр бээр соёрхол урьдастаа ба ван нэр хийгээд соёрхуулах хэмээвээс, ганц нэгэн өдрийн хичээл хатуужлаар гүйцсэн бус эгнэгт уйтгар үгүй үзүүлэн хүч өгсөөр ийн соёрхогдвой за.
46. Хаан эзэн маань Ороныг энэ мэт бэлгэтэйеэ соёрхон хүч өгсөн зэргийг нь узуураас үзүүрт хүртэл<sup>25</sup> бичүүлж, бий таш-д цоолгуулах шалтгаан хэмээвээс урагшид дүр дүрс болгож, олон түшмэлийг хомголзуулахын тул буюу за. Би өчүүхэн боол түшмэл Уй суу үл чадах бядуу ойт (оюут)
47. хүн бөгөөтөл урьд товчоон за хадгалсанаас шалтгаалан ядаж аюугаад эмээгээд бий ташийн аялгуусыг шүлэг сэлт зохиож нөгчсөн урьдсын нь нэрийг, ирэн одон явах мөр дээр байгуулах шалтгаан хэмээвээс
48. Дээдсийн хүнд ачийг бишрэн сэтгэж, өдүүлэн алдаршуулаад, хойтсыг бээр хомголзуулахуйяа буюу за
49. Балараас Уйгудын хан нь  
Биш балыкт оршин суун ажгуу.  
Бэрхшээл үгүй баатар эр төрж  
Бэхлэж улсаа сайтар зарчимлажухуй.  
Гажуу дайсныг халхалж, ойр эс халгасан  
Халтирал үгүй хатгалдаж, сайнаа олдсон (сайнд олон бологдсон)  
Хадгалсан (захирсан) мянганаа аваад Хамилаа(Хамилд) тавьсан
50. Хаанаа(хаанд) хүч өгөн нүүж, Юнчанаа нутагласан  
Өсгөлөн урт мод ургаваас л, ойд  
Узуур нь гүнээ үндэслэюү, өтгөний хүйд  
Үл түридэн дэвлэвээс (үл саатан оргилбоос), булаг насад урсгалд  
Урсаад ууршиж үл ширгэюү, аль ба цагт
51. Хаанаас Си нин ван нэр соёрхогдсон Индү  
Халдаж хөвгүүдээ бариулсан ажгуу, Цээжээ нимт  
Ганц Ороны хүч өгснөөр, зөв нь хүнд  
Хамаг бүгдээр нэрсээ бичүүлбэй, бий таш-д хамт  
Хөвгүүд ураг чинь, хотлоор  
Хэрэглэгдэж зэргээр, ноёлбай

<sup>24</sup> Сувд бүхий гэсэн утгатай үг.

<sup>25</sup> Узуураас үзүүр хүртэл- “эхнээс эцэс хүртэл, үүсгэлээс төгсгөл хүртэл, эхээс адаг хүртэл” хэмээх утга.

### Ш. Чоймаа, М. Баярсайхан

52. Хэрлэж засгаас, биесээ сахихуйгаар  
Хэнээ бээр муу эс хэмээгдвэй  
Сургаж эл өгсөн сүегэрийг чинь  
Шөнө өдөр сахиж, эс умартвай  
Суу залиг залбирч явсаар  
Соёрхол хүртвэй, үхсэн ба амьдад  
Гадна Гүн мөрөн нэрт шилтгээндийг<sup>26</sup> нь  
Гайхамшигаа босгож амуу, хүүрийн гэрийг
53. Хааны зарлигийг зайсангуудад, хүртсэндийг нь  
Хаалганд чинь бий таш байгуулбай, ихэд тэли  
Уртад үйлдсэнээр, сайн утга  
Ургаар мандав, өвтэгш сэрэн  
Үл л уйдан бариваас, сэтгэлээ гагц  
Урагшид<sup>27</sup> магтуулахыг, юун эрүтэл буй танаа
54. Жи жин хорин хоёрдугаар он, барс жил арван сарын арван хоёроо байгуулбай.  
Саду саду.

### Ном зүй

1. Dobu, Uiyurjin mongyol üsüg-ün durasqaltu bičig-üd, Begejing, 1983, 345-413
2. F. W. Cleaves, The Sino-Mongolian Inscription of 1362 in Memory of Prince Hindu, HJAS 12, 1949, 1-133
3. Igor de Rachewiltz, Index to the Secret History of the Mongols, Indiana University, Bloomington, 1972, 347 p.
4. Irinčin-ü mongyol sudulul-un бүтүгел-үн čiyulyan, ÖMAKQ, 2001, 627-693 дүгээр талд.
5. L. Ligeti, Monuments Préclassiques. I. XIII<sup>e</sup> et XIW<sup>e</sup> siècles, Budapest, 1972, 63-75
6. L. Ligeti, Monuments Préclassiques. I. XIII<sup>e</sup> et XIW<sup>e</sup> siècles, Budapest, 1972, 18-70
7. Tulyayuri, “Indü ong-un kösiy-e”-yin mongyol bičig-ün sudulul, Kökeqota, 1992, 1-443
8. Tulyayuri, B. Sodu, “Indü ong-un kösiyen-ü bičig” deki teyin ilyal-un dayaburi “i, -yi”- eče sedüblekü ni, MKUJ 4, 1997, 39-46
9. Tulyayuri, Indü ong-un kösiyen-ü bičig-ün tuqai, ÖMNSÜ 5, 1997, 17-28

<sup>26</sup> Албан байгууллагын нэр. Тулгуурын номын 148т

<sup>27</sup> Ирээдүй цагийг заасан утга.